## IV. МЭДЭЭЛЖСЭН НИЙГЭМ

**Интернэт хувь хүмүүст хэрхэн нөлөөлөх вэ?**

Интернэт болон МХТ-ийн хувьсгал нь "хараат бус/бие даасан хувь хүмүүс" -ийг бий болгож байна. Эдгээр нь сурах шинэ боломж; шинэ санаа, бүтээгдэхүүн, үйлчилгээгээ бусдад шууд худалдах; эрүүл мэнддээ санаа тавих өөрийн сонголтоо хийх анагаахын мэдээлэл авах зэрэг боломжоор хангагдсан хүмүүс юм. Тэд мөн засгийн газрын бодлого, хөтөлбөрийн талаар хамгийн сүүлийн үеийн найдвартай мэдээллийг авч чадах учир илүү сайн иргэн байх боломжтой.

Цаашилбал, Интернэт нь харилцахад хялбар, нэр нууцлагдмал байж болох учир зарим хүмүүс үүнийг сэтгэл зүйн болон сэтгэл хөдлөлөө илэрхийлэх зорилгоор ашиглах нь ч бий. Сүлжээ нь зөвхөн бизнес хийх төдийгүй нийгмийн болон хувийн түвшинд бусадтай харилцах арга хэрэгсэл болсон байгаагаас гадна мөн сүүлийн үед сэтгэц судлалын судлагдахуун болсон байгаа билээ. Торонто хотын Донтох Өвчин Судлалын Сангаас Интернэтэд Донтох Өвчнийг /ИДӨ/ бодит асуудал болсныг нэгэнт хүлээн зөвшөөрөөд байна. Ийм өвчтэй хүмүүс нь бусад ердийн хүмүүсээс илүү компьютертэй харилцахад ихэнх цагаа зориулдаг. Сэтгэц судлаачид ИДӨ-ийг жирийн нэгэн донтолт биш харин хэт авталт, өөрийн хяналтаа алдах, аюултай хэрэггүй гэдгийг нь мэдсээр байж зогсож чадахгүй байх зэргээр тодорхойлогддог бүрэн хамааралтай болох явдал юм гэжээ[1].

Хүмүүст ийм сөрөг нөлөөтэй юм бол Интернэтийг хориглох нь зөв болохгүй юмуу?

Гэвч технологи нь ганц буруутан биш ээ. Роберт Путнам сүүлийн 35 жилд АНУ дахь иргэдийн нийгмийн оролцоо буурсан үзүүлэлт нь нийгэм болон хувь хүмүүст сөрөг үр нөлөө үзүүлсэн талаар баримтжуулан бичжээ.

*Засаглалын чанар нь иргэдийн оролцоо /үл оролцоо/ -ны залгамж холбоогоор тодорхойлогддог. Сонгуульд оролцогчид, сонин захиалагчид, найрал дууны нийгэмлэг болон хөл бөмбөгийн клубын гишүүдийн тоо зэрэг нь гүехэн бус нууцын хэмжлийн чанарын баталгаа болдог. Түүхэн анализаас харахад иргэдийн хамтын ажиллагаа эв нэгдлийн энэхүү зохион байгуулалттай сүлжээ нь нийгэм эдийн засгийн шинэчлэлийн урьдчилсан нөхцөл болсоор иржээ[2].*

*Технологи тэр дундаа Интернэт нь нийгмийн харилцааг өөрчлөхөд тусалж байгаа хэдий ч шүүмжлэгчдийн үзэж байгаа тэр маягаар биш юм. Судлаач Кастелз Интернэтийн нөлөөгөөр хүмүүс өөрсдийгөө нийгмийн сүлжээнд зохион байгуулалттайгаар оруулж байгаагаар тодорхойлсон байна. Тэрээр цааш нь сүлжээгээр холбогдсон хувь хүмүүс нь бие биеэсээ тусгаарлагдсан хүмүүсийн цуглуулга биш, харин нийгмийн харилцааны хэв маяг юм гэжээ. Хүмүүс сонирхол, үнэлэмж, холбоо төсөл зэрэг дээрээ түлгүүрлан* онлайн (интернэтийн сvлжээнд холбогдсон) эсвэл оффлайн (интернэтийн сvлжээнд холбогдоогvй) *сүлжээг бий болгодог. Интернэтээр харилцах боломж их учир биетээр орших нийгэмлэгүүдээс өөр виртуал нийгэмлэгүүдийг бий болгох боломжтой. Гэхдээ эдгээр бүлэглэлүүд нь хүмүүсийг хооронд нь холбон хөдөлгөх нөлөө багатай хүч султай гэж ойлгож бас болохгүй юм. Цаашилбал, орчин үед хөгжиж байгаа харилцааны энэ хэлбэр нь бодит болон виртуал орон зайг нэгтгэн, сүлжээгээр холбогдсон хүмүүст дэмжлэг болж байна[3].*

**Интернэт гэр бүлийн харилцаанд хэрхэн нөлөөлөх вэ?**

Технологи нь бие биенээсээ алс амьдарч буй гэр бүлүүдэд байнгын холбоотой амьдрахад нь тусалдаг. Филиппинчүүд АНУ, Европ сууга төрөл төрөгсөддөө гар утсаар мессеж явуулж байгаа бол хилийн чанадад ажиллаж буй сингапурчууд Интернэтээр дамжуулан ар гэрийнхэнтэйгээ харилцаж байна. Гадаадад амьдарч буй лаосчуудын хүүхдүүд эцэг эхийнхээ төрөлх нутгийн тухай мэнл Интернэтээр дамжуулан мэдэж авах боломжтой болсон байна.

Гэвч сүүлийн үед мэдээллийн болон ажлын хэт ачааллаас болоод хүмүүс гэр бүлтэйгээ бага цагийг өнгөрөөх болсныг үгүйсгэх аргагүй юм Хэдийгээр гэртээ байсан ч гэсэн ажил нь хамаг цагийг нь

---

[1] Гданскийн техникийн их сургуулийн зайн сургалтын төв, "Интернэт: тvvний сэтгэл зvйн vр дагавар" , http://www.dec.pg.gda.pl/archive/1996-1998/englab/internet.html; 2002 оны 8 сарын 31нд өдөр хандсан.

[2] Robert Putnam, "Ганцаараа боулинг тоглох: Америкийн буурч буй капитал", Ардчлал сэтгvvл, 6:1, 1995 оны 1 сар, 65-78; http://muse.jhu.edu/demo/journal_of_democracy/v006/putnam.html; 2002 оны 8 сарын 31нд хандсан.

[3] Кастелз, Интернэтийн галактик, 130-131

авдаг байна. Өнөө үеийн эдийн засгийн шаардлагад нийцүүлэхийн тулд шинэ гэр бүл нь өөрсдөдөө зориулах цагийнхаа хуваарилалтыг хийх хэрэгтэй гэж Рейнбич жээ[4].

Гэр бүлийн дотор гарч буй бүтэц хандлагын өөрчлөлтүүд 1970–аад оноос эхэлсэн эдийн засгийн системийн өөрчлөлтүүдтэй шууд хамааралтай юм. Бүтээгдэхүүнийг их хэмжээгээр үйлдвэрлэдэг байсан хуучин тогтолцооны үед ихэнх эрчүүд байнгын ажилтай тогтмол цалинтай байсан бол эмэгтэйчүүдэд ажил хийх боломж бага байсан. Харин байнгын шинэчлэлийн энэ системд цалин орлогын хэмжээ урьдчилан хэлэхэд төвөгтэй болж орлогын хэмжээ өөр өөр болсон. Энд мөн цаг хугацаа, сэтгэл санаагаа ихээр зарцуулахыг шаардах болсон[5].

Гэхдээ шинэ эдийн засаг нь илүү шахуу ажиллахыг шаардахын хирээр авъяаслаг эрэгтэйчүүд ба эмэгтэйчүүдэд ахиу мөнгө олох эрх тэгш боломж ууьдыг бий болгоонөгч байгаа билээ.

Олон эмэгтэйчүүд ажил хийх үү, эрэгтэй тэжээгчээс хамааралтай амьдрах уу гэсэн сонголтыг хийх боломжтой болоод байна[6].

Ажилд авахад хүйс болон үндэс угсаа голлох үзүүлэлтүүд байхаа больж авъяас чадварыг голлон харгалзах болно

**МКТ нь нийгэмлэгүүдэд хэрхэн нөлөөлдөг вэ?**

МКТ нь нийгэмлэгүүдийг орон зайгаар хязгаарладаггүй. Эдгээр сонголтын нийгэмлэгүүдэд ойр байна гэдэг нь хувийн харьцаатай байна гэсэн үг биш ээ. Сонголтын нийгэмлэгүүд нь Вэв хэлэлцүүлэг, мэдээллийн бүлгүүд, шуудангийн жагсаалт гэх мэт сэдвээр зохион байгуулагдсан байдаг. Бие биенийгээ танихгүй ч сонирхол нэгтэй хүмүүс харилцан зөвлөгөө өгч, мэдээлэл солилцож и-мэйл бичилцэж болох юм. Төрөл бүрийн асуудал, сонирхлын бүхий л салбар төрлүүдээр онлайн хэлэлцүүлэг явагддаг бөгөөд хүмүүс нийтлэг ашиг сонирхол, сэтгэлийг зовоож буй асуудал зэрэг өөр олон зүйлсээрээ ижил төсөөтэй хүмүүстэй холбоо тогтоон нөхөрлөх боломжтой.
Иймч учраас Кастеллз Интернэтийг хэрэглэх нь нийгмийн орчноос буурууллж нийгмээс ихээхэн тусгаарладаг гэдэгтэй санал нэгдэхгүй байна гэээд, харин зарим тохиолдолд тухайлбал, донтох өвчтэй, алив зүйлд хэт автамхай хүмүүсийн хувьд л Интернэт нь нийгмийн үйл ажиллагааг орлож болох юм гэж ээ.

Хүснэгт 10. Ashaninka@the Peruvian Amazon

*Андын нурууны Перугийн хэсэг Амазоны ширэнгэн ой дотор өвсөн дээвэртэй модон байшин дахь баннан ширээн дээрх нэгэн компьютер нь Интернэт хуудсуудаар аялуулж хувьсгалын элч болж байна.*

*Ашанинка нутгийн нэгэн тосгоны уугуул иргэдийн ээлжилж байгаа тэдний нэрлэдэгээр Маранкиари Бажо буюу цайвар шаргал өнгөтэй энхүү хайрцаг нь Интернэтэд өндөр чадлын радиогоор холбогдсон юм. Далайн түвшинээс 500м өндөрт, нийслэл Лимаа хотоос 400 км ийн зайд оршиx энэ бяцхан суурин нь дэлхий ертөнцөөс нэн алслагдмал юм. Тэдний хувьд Ашанинка нутгийн зэргэлдээх суурингийн иргэдтэйгээ сүлжээгээр холбогдсон байгаа нь чухал байгаа юм. Саяхныг болтол тэд телефонутас ч гэж мэддэггүй байсан билээ.*

*Ашанинкачууд Интернэтийг Хойд Америкийн соёлын дайралт гэж хүлээн аваагүй. Харин Өмнөд Америкаар тархсан 400 Ашанинка тосгоны соёлыг өвлөн уламжлуулах нэгдмэл өргөн хүрээтэй зорилгыг бий болгох, өөрсдийн тухай дэлхий дахинд танилцуулах хэрэгсэл болгоод байна. Тэд өөрсдийг нь гадуурхаж байна гэж үздэг гадаадын мэдээллийн хэрэгсэл, засгийн газруудаар дамжуулахгүй байгаа юм*
*... Интернэт төлэхийн хирээр соёл нь амнаас ам дамжихын оронд бичгийн хэлбэрээр хадгалагдах болоод байна. Эцэг эхчүүд үр хүүхдүүдээ тэдний мэдэхгүй зүйлийг сурч мэднэ гэдэгт найдаж байгаа юм. Гэвч нутгийн буурлуудад Маранкиари Бажоос ч том ертөнцөд хөл тавихаар зэхэж байгаа залуу үеийнхэндээ өвлүүлж үлдээх зүйл их бий биз ээ. Тэд мөн зөвхөн зэргэлдээх тосгонукоо иргэдээр зогсохгүй дэлхийн томоохон улс үндэстнүүдтэй стратегийн холбоотнууд болох боломжтой болж байна гэж Кастрохэлж байна.*

“Заримдаа хуримтлуулсан туршилгаа нэгтгэн дүгнэхэд хэцүү байдаг гэхдээ бид олон найз нөхөдтэй болж ярилцаж зөвшилцөж сурсан. Энэ нь манай бүс нутгийн чадавх, боломжоо нэмэгдүүлж өгсөн. Бидэнтэй адил нөхцөл байдалд байдаг олон хүмүүс байдаг юм байна, бид ганцаараа биш юм байна гэдгийг мэдэж авсан“ гэж тэрээр өгүүлсэн юм

4 Рейч, Амжилтын ирээдүй, 158.
5 Ibid., 174
6 Ibid., 175

Эх сурвалж: Keane Shore, “Ashaninka@the Peruvian Amazon,” in Repotrs5 Science from the Developing World, International Development Research Centre [home page on-line]; available from http://www.idrc.ca/reports/read_article_english.cfm?article_num=837; accessed 28 August 2002

**Харилцаа холбооны бусад технологиуд Интернэтийн нэгэн адил нийгэмд нөлөөлдөг үү?**

Хөгжиж буй орнуудад компьютер ашигласан интернэтээс гадна харилцааны хамгийн өргөн тархсан хэлбэр нь гар утас юм Энэ нь Азийн ихэнх орнуудад танил хэрэгсэл болоод байна. Сонирхолтой нь гар утсыг зөвхөн ярихад төдийгүй богино мессеж бичихэд их ашиглаж байгаа нь юм Хөгжиж буй орнуудад олон хүмүүс интернэтэд компьютерээс илүүтэйгээр гар утсаар холбогдож байна.

Гар утас нь мөн харилцах хүн, цаг хугацаа, газар зэргээ чөлөөтэй сонгох боломжтой илүү хувийн харилцаан дээр тулгуурласан сонголтын / албан бус /чөлөөт/ сайн дурын олон нийтийн нийгэмлэгүүдийн хүрээлэлд /орчинд бий болсон нийгмийн харилцааны хэв маягт тохирч байна гэж Кастеллз бичээд гар утсаар Интернэтэд холбогдох нь нийгмийн асуудалд хувь хүмүүс сүлжээгээр хамрагдах хүрээг тэлж, тэдний нийгмийн харилцааны бүтцийг дахин өөрчлөх чадварыг ихэсгэж байгаа юм гэжээ.[7]

*Карнеги Меллоны Их Сургуулийн Хүний Харилцаа Судлалын Хүрээлэнгийн ажилтан Краут, Лундмарк нар судалгаан дээрээ үндэслэн Интернэт нь сэтгэл санаа болон нийгмийн хэрэгцээг хангахад амьд харилцааг орлож чадахгүй юм хэмээн анхааруулга гаргажээ. Интернэт нь зугаатай, ашигтай х хэдий ч бодит амьдралаас хэт их тасрах юм бол хор уршигтай байж болох юм Энэ технологи нь илүү ашигтай болтол Интернэтийн хэрэглээгээ багасгаж хэрэглээндээ хяналт тавих хэрэгтэй. Мэдээллийн харилцааны сүлжээг тойрон / хүрээлэн бий болсон виртуал нийгэмлэгүүдэд үр ашигтай болох нь тодорхой болоход тэнцвэр хадгалагдаж нийгмээс тусгаарлагдмал байдал багасна.*

---

[7] Ibid., 175